



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

ЗӨВЛӨМЖ

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 12/14

Номгон

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын  
санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад  
зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах тухай

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, албаны даргын баталсан 07/02 дугаар удирдамжийн дагуу Шинэжинст сумын Эхэнхавцгай 4 дүгээр багт байрлах Засаг даргын Тамгын газрын 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийг дуустал хугацаанд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчилд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Эрх зүйн чадамжтай шийдвэр гаргах, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.6 дахь “Хууль бус захиргааны акт гэж эрх зүйн зөрчилтэй захиргааны ойлгоно”, 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх “утга агуулгын илэрхий алдаатай”, 47.1.6 дахь “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

2. Дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажиллах, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.

3. 251,300 төгрөгийн өр төлбөр, 20,292,700 төгрөгийн авлагыг барагдуулах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэх.

4. Цагдаагийн албан хаагчтай гэрээ байгуулан, гэрээний дагуу холбогдох зардлыг олгох, Цагдаагийн албаны тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 дэх “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно” гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

5. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хэрэгжүүлэх ажлын байгаль хамгаалал, нөхөн сэргээлтийн зардлын 2022 оны 3,550,000 төгрөгийг холбогдох байгууллагуудаар төлөвлөгөөний дагуу оруулах, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Ашигт малтмалын асуудлаар аймгийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 12.1.3 дахь “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг

642312136

хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих” гэсэн заалтыг хэрэгжүүлэх

6. Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг бүрэн арилгаж хариуг дараагийн хяналт шалгалтын зөвлөмжийн хамт ирүүлэх, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 10.2 дахь “Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагчийн акт, албан шаардлага, гаргасан үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжийг шалгалтад хамрагдсан байгууллагын удирдлага, албан хаагчид хэрэгжүүлэх үүрэгтэй” гэснийг хэрэгжүүлэх.

7. Шинэжинст сумын ЭМТ-ийн барилгын ажлыг дуусгуулах арга хэмжээ авах, дуусгах боломжгүй хариу ирүүлсэн нөхцөлд Сангийн яамны Тендерт оролцох эрхийн хязгаарлах этгээдийн бүртгэлд бүртгүүлэхээр аймгийн Худалдан авах ажиллагааны газарт албан бичгээр хүргүүлэх.

8. ЗДТГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй малыг багийн Засаг дарга нар борлуулан 5,130,000 төгрөг гар дээр байсныг өмнөх хяналт шалгалтаар ИТХ-аар шийдвэр гаргуулан төлүүлж төвлөрүүлэхээр үүрэг өгөгдсөнийг ИТХ-аар шийдвэр гарган 3,960,000 төгрөгийг ОНХС-ийн дансанд оруулж, 1,170,000 төгрөгийг төвлөрүүлээгүй байгааг төвлөрүүлж ажиллах.

9. Хяналт шалгалтын дагуу төлөвлөгөө боловсруулан ажиллаж шалгалтаар илэрсэн зөрчлийг арилган, 2,457,652 төгрөгийн улсын ахлах байцаагчийн актыг хугацаанд барагдуулан ажиллах.

10. Ажилдаа хариуцлагагүй хандсан сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Засаг даргын Тамгын газар болон сан хариуцсан нягтлан бодогч нарт хариуцлага тооцох.

11. Хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, хариуг албан бичгээр 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг Шинэжинст сумын Засаг дарга Б.Бат-Эрдэнэ, Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батхуяг нарт хариуцуулсугай.

12. Зөвлөмжийг биелүүлж хариу ирүүлээгүй тохиолдолд Дотоод аудитын дүрэмд заасны дагуу арга хэмжээ авч ажиллахыг анхааруулсугай.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ

Д.МӨНХХАНД

ХҮЛЭЭН АВСАН:

ЗАСАГ ДАРГА  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА  
НЯГТЛАН БОДОГЧ  
НЯГТЛАН БОДОГЧ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Л.БАТХУЯГ

Х.ДОРЖСАМБУУ

С.ХИШИГТОГТОХ

